

МОНГОЛ ГАЗРЫН ТОС
БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР ТӨХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2020 оны 09 дугаар сарын 20

№ 4/06

Улаанбаатар хот


Журам шинэчлэн батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3.4, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2019 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн н/05/05 дугаар зөвлөмж, Засгийн газрын 2019 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 196 дугаар тогтоол, Компанийн дүрмийн 10.6.12 дугаар заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:


1. Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн “Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Гүйцэтгэх захирлын 2019 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн А/36 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.
3. Энэхүү журмын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хууль эрх зүйн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /О.Батхүү/-д үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Д.АЛТАНЦЭЦЭГ



Гүйцэтгэх захирлын 2020 оны 01 дугаар сарын 20-ны өдрийн 4/тототушаалын Хавсралт-1



МОНГОЛ ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР ТӨХХК-ИЙН БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ЖУРАМ

Нэг. Үндэслэл

- 1.1. Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК /цаашид “Компани” гэх/-ийн “Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах журам” /цаашид “журам” гэх/ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3.4 дэх заалт, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2019 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн н/05/05 дугаар зөвлөмж, Монгол Улсын Засгийн газар, БНЭУ-ын Экспорт-Импортын банк хооронд байгуулсан Зээлийн ерөнхий хэлэлцээр /цаашид “Зээлийн ерөнхий хэлэлцээр” гэх/, Засгийн газрын 2019 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 196 дугаар тогтоолыг тус тус үндэслэв.

Хоёр. Зорилго, хамрах хүрээ

- 2.1. Энэхүү журмын зорилго нь Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт байгуулагдах Газрын тос боловсруулах үйлдвэр, түүний дэд бүтэц, “Газрын тосны үйлдвэрийн хотхон” болон газрын тос дамжуулах хоолойн бүтээн байгуулалтын хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3.4 дэх заалтын дагуу бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 2.2. Энэхүү төсөлтэй холбоотой байгуулагдсан Монгол Улсын олон улсын гэрээ, Зээлийн ерөнхий хэлэлцээрийн хавсралтад заасан “Сонгон шалгаруулалт болон худалдан авалтын журам”, түүнчлэн компанийн Төслийн менежментийн зөвлөх компанитай байгуулсан гэрээ, хамтран боловсруулсан тендерийн баримт бичигт энэ журамд зааснаас өөрөөр заасан бол тухайн гэрээ, журмыг баримталж болно.
- 2.3. Зээлийн ерөнхий хэлэлцээрийн журмын дагуу сонгогдсон гэрээлэгч компаниас туслан гүйцэтгэгч санал болгох хүсэлтийг манай компанид гаргасан нөхцөлд туслан гүйцэтгэгчийг энэхүү журмын дагуу сонгож, санал болгоно.
- 2.4. Энэ журамд хамаарахгүй бусад худалдан авалтыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу хийнэ.

Гурав. Нэр томъёоны тайлбар

- 3.1. Журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:
 - 3.1.1. “Худалдан авалт” гэж энэ журмын 2.1.-д заасан бүтээн байгуулалтын ажилд шаардлагатай бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг сонгох, гэрээ байгуулах ажиллагааг;
 - 3.1.2. “Ажлын хэсэг” гэж энэ журмын дагуу худалдан авалтыг зохион байгуулах, үнэлгээ өгөх зорилгоор байгуулагдсан ажлын хэсгийг;
 - 3.1.3. “Бараа” гэж төслийг хэрэгжүүлэхэд ач холбогдол, үнэ бүхий худалдаж, солилцож болох зүйл болон тухайн барааг нийлүүлэхэд шаардагдах ажлыг;
 - 3.1.4. “Ажил” гэж төсөлтэй холбоотой барилга байгууламж, газар шороо, зам, дэд бүтэц, геологи-хайгуул, бүтээн байгуулалттай холбоотой бүхий л ажил,

- барилгын тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалт, туршилт тохируулгын ажил, түүнчлэн тухайн ажлыг гүйцэтгэхэд шаардагдах бараа нийлүүлэлтийг;
- 3.1.5. “Үйлчилгээ” гэж зөвлөх болон бусад үйлчилгээг;
- 3.1.6. “Захиалагч” гэж Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийг,
- 3.1.7. “Худалдан авалтын баталгаа” гэж гэрээ байгуулах хүртэл, эсхүл худалдан авалт хүчинтэй байх хугацаа дуустал худалдан авалт хүчин төгөлдөр байх, шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах, хариуцлагатай оролцохоо баталгаажуулж худалдан авалтад оролцогч этгээдээс захиалагчид ирүүлсэн банкны баталгаа;
- 3.1.8. Энэ журамд тусгайлан зааснаас бусад нэр томъёо болон зохицуулалтыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулинд заасан агуулгаар ойлгоно.
- 3.1.9. Энэ журамд тусгайлан зохицуулснаас бусад тохиолдолд Сангийн сайдын баталсан жишиг баримт бичгийг баримтална.

Дөрөв. Худалдан авах ажиллагааны зарчим

- 4.1. Худалдан авах ажиллагаанд түргэн шуурхай, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална.
- 4.2. Худалдан авалт нь үндэсний болон олон улсын стандарт, техникийн шаардлага, норм, норматив, дүрэм, зааварт үндэслэх бөгөөд үндэсний стандарт, техникийн норм байхгүй тохиолдолд Монгол Улсын хүлээн зөвшөөрсөн олон улсын стандартад үндэслэнэ.
- 4.3. Төрийн нууцад хамрагдсан худалдан авалтыг зохион байгуулахад төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомжийг чанд баримтална.

Тав. Шууд болон харьцуулалтын арга хэрэглэх нөхцөл, босго үнэ

- 5.1. Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа дараах нөхцөл шаардлага, эсхүл босго үнийн аль нэгийг хангаж байгаа бол шууд болон харьцуулалтын аргаар худалдан авалтыг хийнэ. Үүнд:

№	Худалдан авалт	Нөхцөл, босго үнэ	Сонгох арга
1	Дотоод	<ul style="list-style-type: none"> • Зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд хийгдэх худалдан авалт • Нийлүүлэгч нь хязгаарлагдмал, эсхүл инженерчлэл, технологи, оюуны өмч, патент/лиценз эзэмшигчтэй холбоотой худалдан авалт • Төрийн өмчит болон төсвөөс санхүүждэг байгууллагаас хийх худалдан авалт • Анхны гэрээлэгчээс дахин худалдан авалт хийх • Худалдан авсан ажлын нэмэлт болон түүнтэй ижил төстэй ажлыг давтан хийх шаардлагатай бол, эсхүл нийлүүлэгчийг сольсон тохиолдолд техникийн хүндрэл учруулах, үргүй зардал гарахаар бол анхны гэрээний үнийн дүнгийн 30 хувиас хэтрэхгүй хэмжээний худалдан авалт 	Шууд

		<ul style="list-style-type: none"> Төслийн менежментийн зөвлөх компанитай байгуулсан гэрээний үүргийн хүрээнд, батлагдсан төлөвлөгөөний дагуу хийх худалдан авалт Захиалагч компанийн хэвийн үйл ажиллагаа алдагдах нөхцөл байдал үүссэнтэй холбоотой худалдан авалт Бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг нь 100 сая төгрөг хүртэлх худалдан авалт 	
		Бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг нь 100,000,001 төгрөг буюу түүнээс дээш өртөгтэй худалдан авалт	Харьцуулалт
2	Гадаад	<ul style="list-style-type: none"> Зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд хийгдэх худалдан авалт Нийлүүлэгч нь хязгаарлагдмал, эсхүл инженерчлэл, технологи, оюуны өмч, патент/лиценз эзэмшигчтэй холбоотой худалдан авалт Анхны гэрээлэгчээс дахин худалдан авалт хийх Худалдан авсан ажлын нэмэлт болон түүнтэй ижил төстэй ажлыг давтан хийх тохиолдолд анхны гэрээний үнийн дүнгийн 30 хувиас хэтрэхгүй худалдан авалт хийх Төслийн менежментийн зөвлөх компанитай байгуулсан гэрээний үүргийн хүрээнд, батлагдсан төлөвлөгөөний дагуу хийх худалдан авалт Захиалагч компанийн хэвийн үйл ажиллагаа алдагдах нөхцөл байдал үүссэнтэй холбоотой худалдан авалт Бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг нь 100,000 ам.доллар хүртэлх худалдан авалт 	Шууд
		Бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг нь 100,001 ам.доллар буюу түүнээс дээш	Харьцуулалт

Зургаа. Худалдан авалт хийх аргачлал

6.1. Шууд худалдан авалт хийх

6.1.1. Энэ журмын 5.1 дэх хэсэгт заасан шууд худалдан авах нөхцөл бүрдсэн бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа шууд гэрээ байгуулна.

6.2. Харьцуулалтын аргаар худалдан авалт хийх

6.2.1. Энэ журмын 6.1 дэх хэсэгт хамаарахгүй бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа харьцуулалтын аргыг хэрэглэнэ.

6.2.2. Харьцуулалтын аргаар худалдан авалт хийхэд холбогдох төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, мэргэжлийн холбоодоос гаргасан тусгай зөвшөөрөл бүхий байгууллагуудын жагсаалтад орсон, захиалагчид хамтран ажиллах хүсэлт гаргасан аж ахуйн нэгжүүд, орон нутгийн компаниудаас 3-аас доошгүй этгээдийг сонгож, санал авах албан бичиг хүргүүлнэ.


6.2.3. Санал авах албан бичиг хүлээн авсан этгээд нь нууцын баталгааны маягтад гарын үсэг зурж, баримт бичгийг үнийн саналын хамт битүүмжлэн ирүүлнэ. Худалдан авалтад оролцогч этгээдийн битүүмжлэн ирүүлсэн баримт бичгийг Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга хүлээн авч, бүртгэнэ.

Долоо. Худалдан авах ажиллагааны зохион байгуулалт

- 7.1. Худалдан авалтыг зохион байгуулах, ирүүлсэн саналыг үнэлэх үүрэг бүхий Ажлын хэсгийг тухай бүр байгуулна.
- 7.2. Ажлын хэсэг нь дарга, нарийн бичгийн дарга болон гишүүдээс бүрдсэн 3-аас доошгүй гишүүний бүрэлдэхүүнтэй байна. Шаардлагатай тохиолдолд ажлын хэсэгт холбогдох яам болон мэргэжлийн байгууллагын төлөөллийг оруулж болно.
- 7.3. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орсон этгээд дараах шаардлагыг хангасан байвал зохино. Үүнд:
 - 7.3.1. Санал ирүүлж байгаа этгээд болон түүнийг төлөөлөх этгээдтэй ашиг сонирхлын зөрчилгүй байх;
 - 7.3.2. Сүүлийн 3 жилийн хугацаанд санал ирүүлэгчтэй хөдөлмөрийн болон ажил гүйцэтгэлийн гэрээний харилцаанд ороогүй байх.
- 7.4. Ажлын хэсэг нь дараах журмаар ажиллана. Үүнд:
 - 7.4.1. Ажлын хэсэг нь үнэлгээний аргачлаллыг худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төрөл, онцлог, тусгай шаардлага зэргийг үндэслэн тухай бүр сонгоно.
 - 7.4.2. Ажлын хэсэг шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагын туслалцаа авч болно.
 - 7.4.3. Санал авах баримт бичгийг боловсруулж, нууцын баталгааны маягт бэлтгэх, хүлээн авна.
 - 7.4.4. Ажлын хэсэг нь худалдан авалтад оролцогч этгээдээс ирүүлсэн бичиг баримт, саналыг ажлын даалгавар, техникийн тодорхойлолт болон бусад тавигдсан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянаж, үнэлгээ хийнэ.
 - 7.4.5. Ажлын хэсэг нь хамтын шийдвэрээр үнэлгээний дүгнэлт гаргаж, гэрээ байгуулах эрх олгох тухай зөвлөмжийг захиалагчид танилцуулж, гэрээ байгуулахад арга зүйн туслалцаа үзүүлнэ.
 - 7.4.6. Худалдан авалтад оролцогчдоос ирүүлсэн бүх санал нь шаардлага хангахгүй тохиолдолд энэ журамд заасны дагуу компаниудыг дахин сонгож, санал авах баримт бичиг хүргүүлнэ.
 - 7.4.7. Ажлын хэсэг нь худалдан авалттай холбоотой бичиг баримтыг тухай бүр компанийн гэрээ/нууц хариуцсан ажилтанд хүлээлгэн өгнө.

Найм. Гэрээ байгуулах эрх олгох

- 7.1. Гүйцэтгэх захирал нь ажлын хэсгийн дүгнэлт, зөвлөмж, холбогдох баримт бичигтэй танилцаж, тухайн бараа, ажил, үйлчилгээг нийлүүлэх боломжтой худалдан авалтад оролцогчтой хэлэлцээ хийх тухай мэдэгдлийг албан бичгээр хүргүүлнэ.
- 7.2. Гэрээний хэлэлцээ амжилтгүй болсон бол удаах шаардлага хангасан оролцогчтой гэрээ байгуулах хэлэлцээ хийж болох бөгөөд ийм оролцогч байхгүй бол шууд гэрээ байгуулна.
- 7.3. Гэрээ байгуулахаас өмнө гүйцэтгэлийн баталгаа ирүүлэхийг шаардаж болно.
- 7.4. Сонгогдсон оролцогчтой Төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомжийн хүрээнд Нууц үл задруулах гэрээ байгуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд Аюулгүй байдлын гэрчилгээг холбогдох байгууллагаас авна.
- 7.5. Худалдан авах ажиллагаанд оролцогчдод үнэлгээний үр дүнг мэдэгдэнэ.



БАТАЛГААНЫ МАЯГТ (загвар)

(“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-д хамаарах нууцын болон худалдан авалтын журмыг хүлээн зөвшөөрч байгаа тухай)

Дугаар

20... он сар өдөр

/Хуулийн этгээдийн нэр/

/Эцэг /эх/-ийн нэр, нэр/

/Салбар, нэгжийн нэр/

/Регистрийн дугаар/

/Албан тушаал/

“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-иас ирүүлсэн

.....
.....худалдан авалтад оролцох тухай санал гаргахтай холбогдуулан дараах баталгааг гаргаж байна:

- Төрийн болон албаны нууцын тухай хууль болон “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн нууцын журам”-тай танилцаж, тэдгээрт заасан нөхцөл, шаардлагыг чанд мөрдөхөө илэрхийлж, баталгаа гаргаж байна.
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3.4, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2019 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн н/05/05 дугаар зөвлөмж, Засгийн газрын 2019 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 196 дугаар тогтоолыг үндэслэн батлагдсан Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн “Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах журам”- тай танилцаж, энэхүү журамд заасан нөхцөл, шаардлагыг дагаж мөрдөхөө илэрхийлж, баталгаа гаргаж байна.

..... /эцэг /эх/-ийн нэр/ миний бие ажил, үүргийн дагуу танилцсан эсхүл мэдсэн төрийн нууцын зэрэглэлтэй “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн аливаа баримт бичгийг хадгалж, хамгаалахаа баталж байгаа бөгөөд бусдад задруулсан, үрэгдүүлсэн, хувилсан, олон нийтийн сүлжээ болон бусад хэвлэл, мэдээллийн хэрэгслээр түгээсэн тохиолдолд төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээх болно.

Баталгаа гаргасан:

_____ (Эцэг /эх/-ийн нэр, нэр/ _____ (Гарын үсэг)

_____ (Албан тушаал)

Баталгааны маягыг хүлээж авсан: _____ (Албан тушаал)